БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2021/1/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2021 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг:TseenyamA@audit.gov.mn

Аудитор: Б.Нарангэрэл

Утас: 99009293 Цахим хаяг:Narangerelb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ /эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 11
3.Аудитын тайлан ..... 12
3.1. Ерөнхий зүйл ..... 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт..... 12
3.4. Материаллаг байдал ..... 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... 14
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16
3.9. Аудитын илрүүлэлт ..... 17
Аудитын зөвлөмж ..... 17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд..... 17
4. Менежментийн захидал..... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 18



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ТӨРБОЛД ТАНАА

2021. 01. 27. № 2/02

танай ____________ -ны №____________ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

005020823

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,582,990.00** | **16,070,100.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,582,990.00 | 16,070,100.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,582,990.00 | 16,070,100.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,173,940.00 | 1,866,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,335,250.00 | 11,521,550.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,249,300.00 | 1,739,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 824,500.00 | 942,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **590,728,690.86** | **635,125,341.66** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 590,728,690.86 | 635,125,341.66 |
| **392** | **Биет хөрөнгө** | 590,728,690.86 | 602,625,341.66 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 511,201,480.00 | 511,201,480.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -8,786,691.48 | -17,373,382.92 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 121,700,000.00 | 121,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -70,141,666.66 | -79,108,333.30 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40,088,724.42 | 63,048,878.58 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -24,582,949.86 | -21,063,343.03 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,107,367.12 | 39,945,176.96 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,857,572.68 | -15,725,134.63 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 32,500,000.00 |
| 39301 | Программ хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -400,000.00 | -400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 32,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **601,311,680.86** | **651,195,441.66** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **601,311,680.86** | **651,195,441.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 601,311,680.86 | 651,195,441.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 388,903,922.12 | 421,403,922.12 |
| 51101 | Өмч: - төрийн | 388,903,922.12 | 421,403,922.12 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -47,521.34 | 17,336,239.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -47,521.34 | -47,521.34 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 17,383,760.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 212,455,280.08 | 212,455,280.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **601,311,680.86** | **651,195,441.66** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **483,354,111.00** | **532,138,998.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **79,500,111.00** | **31,679,498.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 79,500,111.00 | 31,679,498.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 79,500,111.00 | 30,959,422.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 79,500,111.00 | 30,959,422.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 720,076.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,854,000.00** | **500,459,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 401,854,000.00 | 490,459,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 401,854,000.00 | 490,459,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,000,000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 10,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **418,901,446.72** | **514,755,237.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **418,901,446.72** | **514,755,237.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 418,011,110.72 | 508,555,071.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,521,028.00 | 348,961,119.00 |
| 210101 | Үндсэн цалин | 273,086,028.00 | 348,712,536.00 |
| 210102 | Нэмэгдэл | 30,555,000.00 | 248,583.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,880,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,317,938.00 | 43,074,957.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,046,623.00 | 28,366,175.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,254,263.00 | 2,695,096.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,817,829.00 | 5,232,960.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 563,566.00 | 539,538.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,635,657.00 | 6,241,188.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,707,450.00 | 24,320,655.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,275,067.00 | 3,070,030.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,396,063.00 | 20,510,105.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,036,320.00 | 740,520.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,771,666.00 | 22,889,070.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,181,710.00 | 9,022,290.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,041,050.00 | 8,425,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,614,337.00 | 2,321,630.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 150,000.00 | 840,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,784,569.00 | 2,279,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 130,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 130,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,464,100.00 | 20,654,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,464,100.00 | 20,654,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,721,000.00 | 2,152,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,721,000.00 | 2,152,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,086,950.00 | 12,849,999.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,570,100.00 | 11,164,450.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 402,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 151,800.00 | 209,696.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 24,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 163,050.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 88,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,420,978.72 | 33,522,771.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 869,800.00 | 3,500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,551,178.72 | 27,522,771.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 890,336.00 | 6,200,166.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 700,000.00 | 1,600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 1,600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 190,336.00 | 4,600,166.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 190,336.00 | 4,600,166.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **64,452,664.28** | **17,383,760.80** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **64,452,664.28** | **17,383,760.80** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **404,084,328.00** | **501,296,011.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **720,076.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 720,076.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 720,076.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **404,084,328.00** | **500,575,935.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 401,854,000.00 | 490,459,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 401,854,000.00 | 490,459,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,000,000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 10,000,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 230,328.00 | 116,435.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 230,328.00 | 116,435.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **407,084,328.00** | **492,836,011.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **407,084,328.00** | **492,836,011.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **402,963,664.00** | **485,889,410.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,597,692.00 | 348,658,088.00 |
| 210101 | Үндсэн цалин | 224,953,692.00 | 260,287,318.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,332,000.00 | 79,061,770.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,312,000.00 | 9,309,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,151,936.00 | 43,377,988.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,041,336.00 | 30,179,780.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,920,560.00 | 3,056,017.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,529,000.00 | 3,141,552.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 605,740.00 | 1,520,154.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,055,300.00 | 5,480,485.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,707,450.00 | 24,320,655.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,275,067.00 | 2,939,324.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,396,063.00 | 20,510,105.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,036,320.00 | 871,226.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,426,786.00 | 22,944,730.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,256,800.00 | 8,497,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,578,500.00 | 7,920,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,557,067.00 | 2,476,630.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 103,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 150,000.00 | 1,098,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,884,419.00 | 2,848,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 160,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 160,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 897,000.00 | 21,384,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 897,000.00 | 21,384,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,671,000.00 | 2,152,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,671,000.00 | 2,152,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,561,800.00 | 16,890,549.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,044,950.00 | 15,265,074.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 402,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 151,800.00 | 151,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 163,050.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 88,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 950,000.00 | 6,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,000.00 | 3,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,120,664.00** | **6,946,601.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 3,000,000.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 3,000,000.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 930,328.00 | 2,346,435.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 230,328.00 | 116,435.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 2,230,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 190,336.00 | 4,600,166.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 190,336.00 | 4,600,166.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-3,000,000.00** | **8,460,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **8,460,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **8,460,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 8,460,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 8,460,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-8,460,000.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -3,000,000.00 | 00.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 3,000,000.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 388,903,922.12 | 212,455,280.08 | -64,500,185.62 | 00.00 | 536,859,016.58 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **388,903,922.12** | **212,455,280.08** | **-64,500,185.62** | **00.00** | 536,859,016.58 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 64,452,664.28 | 00.00 | 64,452,664.28 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл** | **388,903,922.12** | **212,455,280.08** | **-47,521.34** | **00.00** | 601,311,680.86 |
| D01 | **2019 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл** | **388,903,922.12** | **212,455,280.08** | **-47,521.34** | **00.00** | 601,311,680.86 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **388,903,922.12** | **212,455,280.08** | **-47,521.34** | **00.00** | 601,311,680.86 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 32,500,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 32,500,000.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 17,383,760.80 | 00.00 | 17,383,760.80 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **421,403,922.12** | **212,455,280.08** | **17,336,239.46** | **00.00** | 651,195,441.66 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 490,459,500.00 | 485,859,334.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 490,459,500.00 | 485,859,334.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 488,229,500.00 | 483,629,334.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 347,940,500.00 | 347,940,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 260,815,000.00 | 259,569,730.00 |
| 210102 | Нэмэгдэл | 77,813,500.00 | 79,061,770.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,312,000.00 | 9,309,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,375,500.00 | 43,375,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,928,600.00 | 30,177,292.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,111,700.00 | 3,056,017.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,489,400.00 | 3,141,552.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 622,300.00 | 1,520,154.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,223,500.00 | 5,480,485.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,627,000.00 | 24,320,655.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,053,000.00 | 2,939,324.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,511,000.00 | 20,510,105.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,063,000.00 | 871,226.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,092,500.00 | 22,944,730.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,184,000.00 | 8,497,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,189,200.00 | 7,920,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,418,500.00 | 2,476,630.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 103,300.00 | 103,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,107,500.00 | 1,098,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,090,000.00 | 2,848,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 162,000.00 | 160,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 162,000.00 | 160,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,224,000.00 | 28,684,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,300,000.00 | 7,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,924,000.00 | 21,384,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,152,500.00 | 2,152,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,152,500.00 | 2,152,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,655,500.00 | 8,050,549.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,030,000.00 | 6,425,074.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 402,000.00 | 402,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 961,200.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 151,800.00 | 151,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 88,500.00 | 88,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6000000.00 | 6000000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2230000.00 | 2230000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,230,000.00 | 2,230,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,230,000.00 | 2,230,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 490,459,500.00 | 485,859,334.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 490,459,500.00 | 485,859,334.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 490,459,500.00 | 485,859,334.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 16.00 | 17.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 01.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **16.00** | **17.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (Т.З) | 01.00 | 01.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 07.00 | 07.00 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 02.00 | 02.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2000000.00** | **10,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2000000.00** | **10,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2000000.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2000000.00 | 10,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2000000.00 | 10,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2000000.00 | 10000000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2000000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2000000.00 | 10,000,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГ ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Төрболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 15-аас 2021 оны 01 дугаар сарын 18–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Прокурорын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 08-ний өдрийн 2/54 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хуулиар хүлээсэн эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих.
- Шүүхэд төрийг төлөөлөн оролцох зэрэг үндсэн чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор аймгийн Прокурорын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Улсын Прокурорын ерөнхий газрын Дотоод хяналт, шалгалтын хэлтсээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2020 оны эхний хагас жилийг хамруулан шалгалт хийсэн бөгөөд илэрсэн асуудлын талаар тайлангийн 3.7 “Шилэн данс” -ны хэсэгт тусгав.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 367354.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 7347.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49883.7 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 10582.9 | 16070.1 | 5487.2 |
| Үндсэн хөрөнгө | 590728.7 | 635125.3 | 44396.6 |
| **Нийт хөрөнгө** | 601311.7 | 651195.4 | 49883.7 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 601311.7 | 651195.4 | 49883.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **601311.7** | **651195.4** | **49883.7** |

Бараа материалын дансны үлдэгдэл 16070.1 мянган төгрөг болж 5487.2 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдад 4 жилийн хугацаатай дүрэмт хувцас, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 635125.3 мянган төгрөг болж 44396.6 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 8460.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны А/288 дугаартай захирамжаар үнэ төлбөргүй олгосон 32500.0 мянган төгрөгийн газрыг шилжүүлэн авсан бөгөөд, Монгол улсын Ерөнхий Прокурорын 2020.09.21-ны өдрийн А/77 тоот тушаалаар 23518.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2020.10.14-ны өдрийн А/79



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

тоот тушаалаар 3091.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2020.10.16-ны өдрийн А/81 тоот тушаалаар 4349.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 30959.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данснаас Монгол улсын Ерөнхий Прокурорын 2020.06.18-ны өдрийн А/55 тоот тушаалаар 10621.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан байна.

Биет бус хөрөнгө нь 32500.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны А/288 дугаартай захирамжаар үнэ төлбөргүй олгосон 32500.0 мянган төгрөгийн конторын газрыг шилжүүлж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 651195.4 мянган төгрөг болж 49883.7 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн засаг даргын 2020 оны А/288 дугаартай захирамжаар үнэ төлбөргүй олгосон 32500.0 төгрөгийн конторын газрыг үнэлж, дансанд тусгасан, мөн 17383.8 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгийн зардлаас шалтгаалжээ.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 532139,0 мянган төгрөг болж өмнөх оноос 48784.8 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2 ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэж, орон сууцны хөнгөлөлт болох 10000.0 төгрөгийн дэмжлэг олгосон байна. Монгол улсын Ерөнхий Прокурорын тушаалаар нийт 30959.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө байна.

Нийт зардал 514755,2 мянган төгрөг өмнөх оноос 95853.8 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал болон урсгал зардлууд байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолоор цалингийн шатлал шинэчлэн тогтоосонтой холбоотой байна. Урсгал засварын зардал нь Прокурорын газрын ажилчдын орон сууцны засварын ажлыг хийж гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

**3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 515120.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 515120.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24660.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Төсвийн төслөөр эд хогшил урсгал засварын зардлыг 60437.5 мянган төгрөгөөр төсөвлөсөн ч 29224.0 мянган төгрөгөөр баталсан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 490459.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 490459.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 490459.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 485859.3 мянган төгрөгийг зарцуулж 4600.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 485859.3 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 306.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 3147.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 2.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 539.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 53.4 мянган төгрөг, байцаан шийтгэх ажиллагааны бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 551.5 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Прокурорын хяналт /70703/ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал /80101/ арга хэмжээг 4048.7 мянган төгрөгөөр, Прокурорын хяналт /70703/ хөтөлбөрийн байцаан шийтгэх /82315/ арга хэмжээ 551.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **Хөтөлбөр 70703** | | | | | |
| **Арга хэмжээ 80101** | | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 478,899.50 | 474,850.80 | 4,048.7 | 99.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 478,899.50 | 474,850.80 | 4,048.7 | 99.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 478,899.50 | 474,850.80 | 4,048.7 | 99.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 347,940.5 | 347,940.5 | 0.0 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,375.50 | 43,375.50 | 0.0 | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,627.00 | 24,320.70 | 306.3 | 98.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,092.50 | 22,944.70 | 3,147.8 | 87.9 |
| 2105 | Нормативт зардал | 162.00 | 160.00 | 2.0 | 98.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,224.00 | 28,684.90 | 539.1 | 98.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,152.50 | 2,152.50 | 0.0 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,825.50 | 1,772.05 | 53.5 | 97.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3500.00 | 3500.00 | 0.0 | 100.0 |
| **Хөтөлбөр 70703** | | | | | |
| **Арга хэмжээ 80102** | | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,230.00 | 2,230.00 | 0.0 | 100.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,230.00 | 2,230.00 | 0.0 | 100.0 |
| 211 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,230.00 | 2,230.00 | 0.0 | 100.0 |
| 2111 | Нэг удаагийн тэтгэмж | 2,230.00 | 2,230.00 | 0.0 | 100.0 |
| **Хөтөлбөр 70703** | | | | | |
| **Арга хэмжээ 82315** | | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,830.00 | 6,278.50 | 551.5 | 91.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,830.00 | 6,278.50 | 551.5 | 91.9 |
| 211 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,830.00 | 6,278.50 | 551.5 | 91.9 |
| 2111 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам | 6,830.00 | 6,278.50 | 551.5 | 91.9 |
| **Хөтөлбөр 70703** | | | | | |
| **Арга хэмжээ 82805** | | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,500.00 | 2,500.00 | 0.0 | 100.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,500.00 | 2,500.00 | 0.0 | 100.0 |
| 211 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500.00 | 2,500.00 | 0.0 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДУГНЭЛТ

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.04.14-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх” журмын шаардлага хангасан албан хаагчдад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгожээ.

Үүнээс Баянхонгор аймгийн Прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ахлах прокурор Д.Эрдэнэсоёл, хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор В.Дэлгэрмаа нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тус бүр 5000.0 мянган төгрөгийг орон сууцны дэмжлэг болгон өгч нийт 10000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 127325.4 мянган төгрөгийн 17, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

| дд | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаандаа байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа нь болоогүй мэдээлэл | Байршуулаагүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 | 0 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 32 | 4 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 83 | 13 | | |
| | **Нийт** | **27** | **151** | **132** | **17** | **2** | **0** |

Улсын Прокурорын ерөнхий газрын Дотоод хяналт, шалгалтын хэлтсээс эхний хагас жилийг хамруулан хийсэн хяналт шалгалтаар Баянхонгор аймгийн Прокурорын газар нь мэдээлбэл зохих 78 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 60, хугацаа хоцроож мэдээлсэн 17, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг хоосон хадгалсан 1 зөрчил илэрчээ.

Уг зөрчилд Монгол улсын Ерөнхий Прокурорын газрын 2020.09.01-ны өдрийн 8/4627 тоот албан бичгээр цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, мэдээллээ цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг анхааруулж, зөрчлийг 2020.10.01-ны дотор арилгаж хариу ирүүлэхээр үүрэг болгосны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2020.10.01-ны өдрийн 2/2065 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн алдаа илрээгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.9. Аудитын илрүүлэлт

Тайлант онд аудитаар нийт 372.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:* Нэг ажилтны ХЧТА-ны байгууллагаас төлөх тэтгэмжийг "Прокурорын тухай хууль"-ийн заалтын дагуу олгохдоо Прокурорын байгууллагын НБББББ-д тусгаснаар цалингийн зөрүү 372317 төгрөгийг нийгмийн даатгалын цалингийн санд мэдээлээгүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*1.2.* *Эрсдэл:* Холбогдох хууль, тогтоомж, заавар журам, стандартыг мөрдөөгүйгээс Зардал буруу илэрхийлэгдэх, зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй.

*1.3.* *Өгсөн зөвлөмж:* Улсын Прокурорын ерөнхий газрын даргын 2016.04.04-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан "Прокурорын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт"-ын “цалин хөлсний бүртгэлийн горим”-д тусгасны дагуу цалингийн санг нийгмийн даатгалд бүрэн мэдээлж, холбогдох заалтыг хэрэгжүүлж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2020 | Аудитын нэр: | *Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит* | Аудитын код: БНА-2021/1/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Баянхонгор аймгийн Прокурорын газар** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Нэг ажилтны ХЧТА-ны байгууллагаас төлөх тэтгэмжийг олгохдоо Прокурорын байгууллагын НБББББ-ын "Цалин хөлсний бүртгэлийн горим"-д тусгаснаар цалингийн зөрүү 372317 төгрөгийг нийгмийн даатгалын цалингийн санд мэдээлээгүй байна.. | 372.3 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Төрболд, Ч.Бодьбямба |
| **ДҮН** | | **372.3** | | | |

Бэлтгэсэн:

АУДИТОР — Б.НАРАНГЭРЭЛ
Огноо: 2021.01.27

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.01.27

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.01.27

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ